



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 1-ний өдөр

Дугаар 23/05

Улаанбаатар хот

### Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргыг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1 дэх хэсэг, “Хот Девелопмент” ХК-ийн Компанийн дурмийн 3.26 дахь заалт болон “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

- “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн даргаар Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүн Э.Баярбат /РД: ФД83101415/-ыг сонгосугай.

#### ЗӨВШӨӨРСӨН :

- Э.БАЯРБАТ
- Ч.СОЛОНГО
- Б.ЧУЛУУНСҮХ
- С.ОТГОНСАЙХАН
- М.ДӨЛГӨӨН
- Э.ЭРДЭНЭБААТАР
- Б.ЛХАМДЭГД
- Э.ГАНБААТАР

  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....  
.....



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 1-ний өдөр

Дугаар 23/06

Улаанбаатар хот

### ТУЗ-ийн гишүүдийг хороонд хуваарилах тухай

Компанийн тухай хуулийн 81 дүгээр зүйлийн 81.2 дахь хэсэг болон “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Аудитын хорооны гишүүдээр дараах гишүүдийг сонгосугай.  
Ч.Солонго  
Э.Ганбаатар  
Э.Эрдэнэбаатар
2. Цалин, урамшууллын хорооны гишүүдээр дараах гишүүдийг сонгосугай.  
Э.Ганбаатар  
Э.Эрдэнэбаатар  
Ч.Солонго
3. Нэр дэвшүүлэх хорооны гишүүдээр дараах гишүүдийг сонгосугай.  
Э.Эрдэнэбаатар  
Э.Ганбаатар  
Э.Баярбат

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Э.БАЯРБАТ





## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 1-ний өдөр

Дугаар 23/07

Улаанбаатар хот

### Гүйцэтгэх захирлыг чөлөөлөх тухай

“Хот Девелопмент” ХК-ийн гүйцэтгэх захирал Н.Батгэрэлийн 2023 оны 2 сарын 13-ны өдөр гаргасан ажлаас чөлөөлөгдхөх хүсэлт болон Хөдөлмөрийн тухай хуулийн 79 дүгээр зүйлийн 79.2 даах хэсгийг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн Гүйцэтгэх захирал Наангэрэл овогтой Батгэрэлтэй байгуулсан контрактыг ажилтны санаачлагаар дуусгавар болгосугай.
2. Н.Батгэрэлд ажлаа хүлээлцэхийг даалгасугай.
3. Н.Батгэрэлтэй ээлжийн амралтын цалингийн тооцоо хийхийг нягтлан бодогчид даалгасугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



 Э.БАЯРБАТ



## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 1-ний өдөр

Дугаар *23/08*

Улаанбаатар хот

### Гүйцэтгэх захирлыг сонгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт болон “Хот Девелопмент” ХК-ийн дүрмийн 3.20.8 дахь заалт болон Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн **ТОГТООХ** нь:

- Хот Девелопмент ХК-ийн Гүйцэтгэх захирлаар Монгол Улсын иргэн Батзориг овогтой Чулуунсүх /РД: ТБ82033073/-ийг сонгосугай.
- Б.Чулуунсүхтэй онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ байгуулах, гэрээний нөхцөлийг тохиролцох, гэрээнд гарын үсэг зурахыг Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга Э.Баяrbатад даалгасугай.
- Б.Чулуунсүхэд онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээнд заасан цалин хөлс, нэмэгдэл, урамшуулал олгохыг нягтлан бодогчид даалгасугай.





## ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 1-ний өдөр

Дуаар *23/09*

Улаанбаатар хот

### Гүйцэтгэх захиралд эрх, үүрэг олгох тухай

Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.8 дахь заалт, хувьцаа эзэмшигчдийн хурлаас баталсан Хот Девелопмент ХК-ийн 2023 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг үндэслэн **ТОГТООХ** нь:

- “Хот Девелопмент” ХК-ийн Гүйцэтгэх захиралд дараах үүргийг даалгаж, холбогдох эрхийг олгосугай.
  - “Хот Девелопмент” ХК-ийн нэр дээр виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл авах ажлыг даалгасугай.
  - Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн зөвшөөрөл авахтай холбогдуулан, гуравдагч этгээдтэй их хэмжээний гэрээ хэлцэл байгуулах эрхийг Гүйцэтгэх захиралд олгосугай.





## “ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 1-ний өдөр

Дугаар 23/10

Улаанбаатар

**Тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх журам батлах,  
худалдан авах хувьцааны үнийг тогтоох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэг, 38 дугаар зүйл болон Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн тус тус ТОГТООХ нь:

1. “Хот Девелопмент” ХК нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,500,000 /хорин сая таван зуун мянга/ ширхэг энгийн хувьцааг нэмж гарган хаалттай хүрээнд эзэмшигчилэхээр шийдвэрлэснийг үндэслэн хувьцаа эзэмшигчид нь нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэхээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас шийдвэрлэснийг дурдсугай.
2. “Хот Девелопмент” ХК нь хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргаж буйтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлэх журмыг хавсралтаар баталсугай.
3. Хувьцааг тэргүүн ээлжид худалдаж авах үнийг нэгж хувьцааны нэрлэсэн үнээр буюу 100 /нэг зуу/ төгрөг байхаар тогтсугай.
4. Уг эрхийг хэрэгжүүлэх, төлбөр тооцоо, бүртгэлд хяналт тавих, мэдээлэл хүргэн ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГАТ Э.БАЯРBAT





“Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2023 оны 3 сарын 1-ний өдрийн ээлжит бус  
хурлын № 23/10 дугаар тогтоолоор батлав.

**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК НЬ ХААЛТТАЙ ХҮРЭЭНД НЭМЖ ХУВЬЦАА ГАРГАЖ  
БАЙГААТАЙ ХОЛБОГДУУЛАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТЭРГҮҮН ЭЭЛЖИД  
ХУВЬЦАА ХУДАЛДАН АВАХ ЭРХИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023 оны 2 сарын 28-ны өдрийн тогтоолоор хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах шийдвэр гарсантай холбогдуулан Компанийн тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1-т заасны дагуу хувьцаа эзэмшигч нь нэмж гаргаж буй хувьцаанаас өөрийн эзэмшиж буй энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрх үүссэн.

1.2 Уг эрхтэй холбогдуулан “Хот Девелопмент” ХК нь Компанийн тухай хуульд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг

2.1 “Компанийн тухай хууль”-ийн 38.1-т заасны дагуу хувьцаа эзэмшигчид нь нэмж гаргаж байгаа энгийн хувьцааг өөрийн энгийн хувьцааны тоотой хувь тэнцүүлэн тодорхой нөхцөлөөр тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.

2.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах шийдвэрийг гаргасан өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид худалдан авах шаардах эрх үүссэн гэж үзэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь тэргүүн ээлжид худалдан авах эрхтэй.

2.3 Хувьцаа эзэмшигч нь энэ журмаар тогтоосон хугацаанд багтаан нэмж гаргаж буй хувьцаанаас тэргүүн ээлжид худалдан авах саналаа компанийд бичгээр хүргүүлэх эрхтэй.

Гурав. Компанийн эрх, үүрэг

3.1 Компани шаардах эрх үүссэн өдөр буюу хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн №377 тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу шаардах эрх үүссэн тухай зарыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио болон телевизийн аль нэгээр хувьцаа эзэмшигчдэд мэдээллийг хүргэх үүрэгтэй.

3.2 Энэ журмын 2.3-т зааснаар ирүүлсэн хувьцаа эзэмшигчийн шаардлагыг хүлээн авч, хууль журамд заасан хугацаанд шийдвэрлэх үүрэгтэй.



Дөрөв. Хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компани хувьцааг эргүүлэн  
худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх

- 4.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Компанийн тухай хуулийн 38.1-т заасан шийдвэрийг гаргасан өдрөөр, хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэж үзнэ.
- 4.2 Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалтыг уг шаардах эрх үүссэн өдрөөр гаргана.
- 4.3 Компани нь хувьцаа эзэмшигчдэд тэргүүн ээлжид худалдан авах эрх үүссэн тухай мэдээллийг "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам"-ын дагуу хүргэнэ.
- 4.4 Компани хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор тэргүүн ээлжид худалдан авах санал/хүсэлтийг компани дээр бичгээр хүлээн авна.
- 4.5 Хувьцаа эзэмшигч нь хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор нэр, оршин суугаа газрын хаяг, худалдан авах хувьцааны тоо, үнийг төлсөн баримтыг компанийд ирүүлснээр тэргүүн ээлжид хувьцааг худалдан авсанд тооцно.
- 4.6 Хувьцаа эзэмшигч нь тэргүүн ээлжид худалдан авах эрхээ бүхэлд нь буюу хэсэгчлэн хэрэгжүүлж болно.
- 4.7 Хувьцаа эзэмшигч нь тэргүүн ээлжид худалдан авах эрхээ бусад этгээдэд бүхэлд нь буюу хэсэгчлэн шилжүүлж болно.
- 4.8 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлтийг ирүүлээгүй, хувьцааны үнийг төлсөн баримтыг ирүүлээгүй тохиолдолд тэргүүн ээлжид худалдан авах эрхээ хэрэгжүүлээгүйд тооцно.

- - оОо- -





**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН  
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2023 оны 3 сарын 1-ний өдөр

Дугаар 23/11

Улаанбаатар

**Хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх хэрэгжүүлэх журам батлах,  
эргүүлэн худалдан авах хувьцааны үнийг тогтоох тухай**

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.5 дахь хэсэг, 53 дугаар зүйл, 54.1, 55.2 болон 55.8 дахь хэсэг болон Төлөөлөн Удирдах зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн тус тус ТОГТООХ нь:

1. “Хот Девелопмент” ХК нь нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 20,500,000 /хорин сая таван зуун мянга/ ширхэг энгийн хувьцааг нэмж гарган хаалттай хүрээнд эзэмшүүлэхээр шийдвэрлэснийг үндэслэн хувьцаа эзэмшигчид нь өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдан авах шаардах эрхийг хэрэгжүүлэхээр хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаас шийдвэрлэснийг дурдсугай.
2. “Хот Девелопмент” ХК нь хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргаж буйтай холбогдуулан хувьцаа эзэмшигчдийн шаардах эрх хэрэгжүүлэх журмыг хавсралтаар баталсугай.
3. Хувьцааг эргүүлэн худалдаж авах үнийг нэгж хувьцааны нэрлэсэн үнээр буюу 100 /нэг зуу/ төгрөг байхаар тогтсугай.
4. Уг эрхийг хэрэгжүүлэх, төлбөр тооцоо, бүртгэлд хяналт тавих, мэдээлэл хүргэн ажиллахыг Гүйцэтгэх захиралд үүрэг болгосугай.





“Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн  
2023 оны 3 сарын 1-ний өдрийн ээлжит бус  
хурлын №23/11 дугаар тогтоолоор батлав.

TT36452 д. 2116812

**“ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК НЬ ХААЛТТАЙ ХҮРЭЭНД НЭМЖ ХУВЬЦАА ГАРГАЖ  
БАЙГААТАЙ ХОЛБОГДУУЛАН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ШААРДАХ ЭРХИЙГ  
ХЭРЭГЖҮҮЛЭХ ЖУРАМ**

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын 2023 оны 2 сарын 28-ны өдрийн тогтоолоор хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах шийдвэр гарсантай холбогдуулан Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1-т заасны дагуу хувьцаа эзэмшигч нь компанид хувьцаагаа эргүүлэн худалдахыг шаардах эрх үссэн.

1.2 Уг эрхтэй холбогдуулан “Хот Девелопмент” ХК нь Компанийн тухай хуулийн 54 дүгээр зүйлд заасан журмын дагуу хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг эргүүлэн худалдан авах ажиллагааг зохион байгуулна.

Хоёр. Хувьцаа эзэмшигчдийн эрх, үүрэг

2.1 “Компанийн тухай хууль”-ийн 53.1-т заасны дагуу хувьцаа эзэмшигчид өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй.

2.2 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас хаалттай хүрээнд нэмж хувьцаа гаргах шийдвэрийг гаргасан өдрөөр, хувьцаа эзэмшигчдэд компанийд хувьцаагаа эргүүлэн худалдах шаардах эрх үссэн гэж үзэх бөгөөд хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцоогүй, хувьцаа эзэмшигчдийн хуралд оролцсон ч эсрэг саналтай байсан хувьцаа эзэмшигчид нь компаниас хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах, хувьцаагаа компанийд худалдах эрхтэй.

2.3 Хувьцаа эзэмшигч нь энэ журмыар тогтоосон хугацаанд багтаан өөрийн эзэмшлийн хувьцаагаа компанийд эргүүлэн худалдах тухай шаардлагыг компанийд бичгээр хүргүүлэх эрхтэй.

Гурав. Компанийн эрх, үүрэг

3.1 Компани шаардах эрх үссэн өдөр буюу хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан өдрөөс Санхүүгийн зохицуулах хорооны 2018 оны 12 сарын 14-ний өдрийн №377 тогтоолоор баталсан “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам”-д заасны дагуу шаардах эрх үссэн тухай зарыг Монголын хөрөнгийн биржийн цахим хуудас, өдөр тутмын сонин, орон даяар нэвтрүүлгээ түгээдэг радио болон телевизийн аль нэгээр хувьцаа эзэмшигчдэд мэдээллийг хүргэх үүрэгтэй.

3.2 Энэ журмын 2.3-т зааснаар ирүүлсэн хувьцаа эзэмшигчийн шаардлагыг хүлээн авч, хууль журамд заасан хугацаанд шийдвэрлэх үүрэгтэй.

3.3 Компани нь Санхүүгийн зохицуулах хорооноос хаалттай хүрээнд нэмж гаргаж буй хувьцааг бүртгэхийг зөвшөөрсөн тухай шийдвэр гарснаар хувьцаа эзэмшигчдийн шаардлагаар хувьцааг худалдан авах төлбөрийг шилжүүлэх үүрэг хүлээнэ.



**Дөрөв. Хувьцаа эзэмшигчийн шаардлагаар компани хувьцааг эргүүлэн  
худалдаж авахыг шаардах эрхийг хэрэгжүүлэх**

- 4.1 Хувьцаа эзэмшигчдийн хурлаас Компанийн тухай хуулийн 53.1-т заасан шийдвэрийг гаргасан өдрөөр, хувьцааг эргүүлэн худалдаж авахыг шаардах эрх үүссэн гэж үзнэ.
- 4.2 Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэrsийн жагсаалтыг уг шаардах эрх үүссэн өдрөөр гаргана.
- 4.3 Компани нь хувьцаа эзэмшигчдэд компанийд хувьцаагаа эргүүлэн худалдах эрх үүссэн тухай мэдээллийг "Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх, хяналт тавих журам"-ын дагуу хүргэнэ.
- 4.4 Компани хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор хувьцаагаа эргүүлэн худалдан авах шаардлагыг компани дээр бичгээр хүлээн авна.
- 4.5 Өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг компаниас шаардах эрхээ хэрэгжүүлэх хүсэлтэй хувьцаа эзэмшигч нь эргүүлж авах тухай шаардлагыг Хавсралт 1-т заасны дагуу бичгээр гаргана.
- 4.6 Хувьцаа эзэмшигчдийн хурлын шийдвэр гарсан өдрөөс хойш ажлын 30 өдрийн дотор шаардах эрх хэрэгжүүлэх хүсэлтийг Хавсралт 1-д заасны дагуу ирүүлээгүй тохиолдолд хувьцаа эзэмшигчээр хэвээр үлдэх саналтай гэж үзнэ.
- 4.7 Санхүүгийн зохицуулах хороо нь компанийн хаалттай хүрээнд нэмж гаргаж буй хувьцааг бүртгэхийг зөвшөөрсөн тухай шийдвэр гаргаснаар компани хувьцааг эргүүлэн худалдан авах шаардлагыг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ.
- 4.8 Компани энэ журмын 4.5-д заасан шаардлагыг хүлээн авч Санхүүгийн зохицуулах хорооноос хаалттай хүрээнд нэмж гаргаж буй хувьцааг бүртгэхийг зөвшөөрсөн шийдвэр гаргаснаас хойш ажлын 15 хоногийн дотор "Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн төв" ХХК дахь хувьцаа эзэмшигчийн үнэт цаасны дансанд хувьцааны мөнгийг байршуулна.
- 4.9 Энэхүү журмын 4.7-д заасан нөхцөл хангагдаагүй бол компани хувьцааг эргүүлэн худалдан авах шаардлагыг хэрэгжүүлэх, хувьцаа эзэмшигчдийн дансанд мөнгө шилжүүлэх, үнэт цаасны данснаас нь хувьцааг татах гүйлгээ хийхийг хориглоно.

- - оОо- -

ИСААТАР ХОТ

ХОТ  
БЛОПМЕНТ  
ХХ

36452 №: 2116812

ИСААТАР ХОТ



“Хот Девелопмент” ХК-ийн хувьцаа эзэмшигчдийн  
шардах эрхийг хэрэгжүүлэх журмын нийт  
Хавсралт №1

ТГ36452 дт. 2116812

“Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлд

Мэдэгдэл хүргүүлэх нь

Хувьцаа эзэмшигч миний бие Компанийн тухай хуулийн 53 дугаар зүйлийн 53.1 дэх хэсэгт заасны дагуу өөрийн эзэмшлийн хувьцааг эргүүлэн худалдаж авахыг “Хот Девелопмент” ХК-аас шардах эрхээ хэрэгжүүлэхээр энэхүү мэдэгдлийг хүргүүлж байна.

Овог, нэр:	
Оршин суугаа хаяг:	
Эргүүлэн худалдаж авахыг шардаж байгаа хувьцааны тоо:	
Төрөл:	
Утас:	

..... / ..... / .....



## “ХОТ ДЕВЕЛОПМЕНТ” ХК-ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2023 оны 3 сарын 1-ний өдөр

Дугаар 23/12

Улаанбаатар

Компанийн дотоод журам, компанийн засаглалын  
бусад журам, заавар, бодлогыг батлах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 76 дугаар зүйлийн 76.1.13, “Хот Девелопмент” ХК-ийн дүрмийн 3 зугаар зүйлийн 3.20.13 дахь заалт болон Санхүүгийн зохицуулах хорооны 2022 оны 3 сарын 23-ны өдрийн 145 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Хот Девелопмент” ХК-ийн Хөдөлмөрийн дотоод журмыг Хавсралт №1 ёсоор баталсугай.
2. “Хот Девелопмент” ХК-ийн Ёс зүйн дүрмийн Хавсралт №2 ёсоор баталсугай.
3. “Хот Девелопмент” ХК-ийн Цалин урамшууллын бодлогыг Хавсралт №3 ёсоор баталсугай.
4. “Хот Девелопмент” ХК-ийн Ногдол ашгийн бодлогыг Хавсралт №4 ёсоор баталсугай.
5. “Хот Девелопмент” ХК-ийн Эрсдэлийн удирдлагын зааврыг Хавсралт 5 ёсоор баталсугай.
6. “Хот Девелопмент” ХК-ийн Дотоод аудитын зааврыг Хавсралт №6 ёсоор баталсугай.
7. “Хот Девелопмент” ХК-ийн Дотоод хяналтын зааврыг Хавсралт №7 ёсоор баталсугай.
8. “Хот Девелопмент” ХК-ийн Комплайнсын хяналтыг Хавсралт №8 ёсоор баталсугай.
9. “Хот Девелопмент” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн хурлын журмыг Хавсралт №9 ёсоор баталсугай.
10. “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн үйл ажиллагааны журмыг Хавсралт №10 ёсоор баталсугай.
11. “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн нарийн бичгийн даргын үйл ажиллагааны журмыг Хавсралт №11 ёсоор баталсугай.
12. “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Аудитын хорооны үйл ажиллагааны журмыг Хавсралт №12 ёсоор баталсугай.
13. “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Нэр дэвшүүлэх хорооны үйл ажиллагааны журмыг Хавсралт №13 ёсоор баталсугай.
14. “Хот Девелопмент” ХК-ийн Төлөөлөн удирдах зөвлөлийн дэргэдэх Цалин, урамшууллын хорооны үйл ажиллагааны журмыг Хавсралт №14 ёсоор баталсугай.
15. “Хот Девелопмент” ХК-ийн Гүйцэтгэх удирдлагын үйл ажиллагааны журмыг Хавсралт №15 ёсоор баталсугай.
16. “Хот Девелопмент” ХК-ийн Мэдээллийн ил тод байдал, тайлагналын журмыг Хавсралт №16 ёсоор баталсугай.
17. “Хот Девелопмент” ХК-ийн Залгамж халааны бодлогыг Хавсралт №17 ёсоор баталсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА *Э.БАЯРБАТ*

